

**УЛС ТӨР**

**ДЭЛХИЙ**

**Улаанбаатарт: ӨНӨӨДӨР**

ЭЛЧИН САЙД НАРЫГ ТОМИЛЖ, ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙГ БУЦААВ

II нүүрт

ХИЛЛАРИ КЛИНТОН: ДЭЛХИЙН ХАМГИЙН ТОМ ГҮРНИЙ ХАГАРАЛ СОНГУУЛИАР Л ИЛ ГАРЛАА

IV нүүрт



Өдөр -14  
Шөнө -16



Дугаарын **60** мөр

ҮЗЭЛ БОДОЛ

Орон нутгийн  
замыг  
камержуулаач

## ХЭН ЮУ ХЭЛЭВ

Н.БАТЗАЯА

Б.ДАВАА

Саяхан орсон цаснаар “Эрдэнэт” хотод ажилладаг дүүтээ эргэчихээд нийслэл рүү буцаж явахдаа авгаарт оров. Хамгийн хөнгөн тэрэг гэгддэг Приус 20 автомашиндаа гэр бүлээрээ “чихэж” суугаад хөдөлсөн бид Улаанбаатараас ердөө 100 км-ийн цаадах замд осолдсон хэрэг. 80 орчим км/ц-ийн хурдтай давхиж байсан машин зам дээр хальгирах үед хэрэг нэгэнт бишидгээ гэж бодсон би нүдээ тас аничихсан байсан учир одоо санах нь ээ хүмүүсийн орилолдох чимээ л санаанд бууна. Хүн гэдэг сонин амьтан юм билээ.

Үргэлжлэл нь III нүүрт

Өнгөрсөн долоо хоногт улс орны нийгэм, эдийн засаг, улс төртэй холбоотой халуун сэдвүүд өрнөлөө. Тэр дундаа монгол мөнгөн тэмдэгт үнэгүйдэж, долларын ханш толгой дээр гарах дөхөө. Өдөр өдрөөр өссөн долларын ханшнаас болж, бүсээ чангалсан байсан улсын төсөв ганхаж, ард иргэдийн амьдралд ч сөргөөр нөлөөлж эхэлсэн. Мөн улс төрийн тогоонд болсон нэг халуун үйл явдал нь Ардчилсан намын Үндэсний зөвлөлдөх хорооны хурал байлаа. Уг хурлын үеэр 2016 оны УИХ-ын сонгуулиас хойш хүлээлгэсэн Ардчилсан намын дараагийн даргыг сонгох байсан юм. Гэсэн ч хуралд Ардчилсан намын лидерүүд ирээгүйгээс болж, энэ асуудал дахин хойшлогдож, дараагийн даргыг сонгох хүртэл 3.Энхболд намаа даргалахаар боллоо. Тиймээс дээрх асуудалд хэн ямар байр суурьтай байгааг энэ удаагийн “Хэн юу хэлэв” булангаараа онцолж байна.

**Д.Бямбасүрэн:**  
Монголын хөрсөнд  
буусан төрийн  
бодлого алга

/Монгол Улсын Ерөнхий сайд  
асан/

-Улс орныхоо эдийн  
засгийг бүхэлд нь эрүүл

ухаанаар хараад дүгнэхэд маш хүнд байгаа нь хэнд ч ойлгомжтой. Улсын төсвийг урд өмнө байгаагүй маш өндөр алдагдалтайгаар баталлаа. Долларын нөөц сүүлийн арван жилд доод хэмжээндээ хүрлээ. Эдийн засгийн өсөлт бодитойгоор дүгнэхэд огт байхгүй болчихлоо. Энэ нь олон жилийн турш гажуудсан

бодлогоор явсны гай нь одоо илэрч байгаа хэрэг. Хямрал, эдийн засгийн уналт гэхээсээ улс орон дампуурлын ирмэгт тулсан гэхэд хилсдэхгүй дүр зурагтай боллоо. Тод илрэл нь сүүлийн үед төгрөгийн ханш үсрэнгүй унаж байна. Долларын ханш маш хурдтай өсч байна. Засгийн газар нь яаралтай арга хэмжээ ав гэсэн үүргийн дагуу Монголбанк их хэмжээний доллар гаргаж тогтворжлоо гэж зарлалаа. Энэ байдлаараа удаан явах аваас долларын нөөц нэг сар ч хүрэхгүй дуусна. Түүнээс гадна өр төлбөр маш их нэмэгдлээ. Мөн төсвийн алдагдал дээд цэгтээ хүрсэн. Энэ хоёр хавхнаас бид яагаад ч зайлж чадахгүй гэдгийг эрх баригчид сайн ойлгохгүй явна. Сонгуулийн үеэр ард түмэндээ үнэн байдлаа огт хэлээгүй. Сайн сайхан байгаа, бүх зүйл болно бүтнэ гэж л хий хоосон амлсаар.

Үргэлжлэл нь III нүүрт

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ



Гэрээ зургиа Г.АРГУУЖИН

## АМГТГ БНСУ-ЫН ТАЛТАЙ ТУРШЛАГА СОЛИЛЦЛОО

Б.ДАВАА

Ашигт малтмал, газрын тосны газар БНСУ-ын “К Петро” газрын тосны газартай хамтран “Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналт” сэдэвт туршлага солилцох хэлэлцүүлгийг өчигдөр Үндэсний хөгжлийн газрын хурлын танхимд зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт БОАЖЯ, ЗТХЯ, УУХҮЯ, ГЕГ, МХЕГ, Стандартчилал хэмжилзүйн газар, ОБЕГ, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим, Газрын

тосны бүтээгдэхүүний импортлогч компаниудын төлөөллүүд оролцлоо. Түүнчлэн, БНСУ-ын талаас К Петро газрын тосны газрын орлогч дарга, төлөвлөлт хяналт шалгалт хариуцсан дарга нарын эрхэм хүндтэй хүмүүс ирж оролцсон юм. Манай улсын хувьд газрын тосны бүтээгдэхүүний хэрэгцээгээ 100 хувь импортоор хангадаг бөгөөд зөвхөн энэ оны эхний 10 сарын байдлаар л гэхэд 965 мянган тонн газрын тосны бүтээгдэхүүнийг импортлон байсан.

Үргэлжлэл нь III нүүрт



БИД ТАНЫ  
АЖЛЫГ ХҮНДЭЛНЭ



Dell –ийн Inspiron, Vostro загварын компьютер худалдан аваад 25.000₮-ийн ваучер бэлгэнд аваарай.

Free Bag + 2 Years + McAfee SECURE

PC mall

7575-3535

Алдаж болохгүй алтан боломж

ХААН банк	Хугалгаа хөгжлийн банк			
	Авах	Зарах	Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2400.00	2446.00	ФУНТ	2933.00
ЕВРО	2539.00	2642.00	РУБЛЬ	35.80
ИЕН	21.83	22.66	ЮАНЬ	348.60

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар



# ҮЗЭЛ БОДОЛ



## ХЭН ЮМ ХЭЛЭВ

**Үргэлжлэл.**  
**Түрүүч нь I нүүрт**

Иргэд бодит байдлыг харж, мэдэрч байгаа ч тэдний амлалт, хэлсэн үгийг сонсож, итгэж, найдан хүлээсээр. Дампуурлын ирмэгт тулсан, хүнд байдалтай эдийн засаг амар сэргэхгүй. Ийм нөхцөл байдалтай байгаагаар ард түмэндээ үнэнээр нь хэлэх нь хамгийн зөв гарц. Монголын эдийн засгийн асуудал, цаашдын төлөв байдлыг монголчууд бид л өөрчилж шинэчилнэ. Хэн нэгэн гаднаас ирээд сайжруулахгүй, сайхан зүйл хийхгүй гэдгийг бүгд мэддэг л баймаар. Энэ асуудлаа үндэсний асуудал болгож, гарах арга замаа ярихад ёстой. Гал унтраах төдий интервенц хийгээд, хойшоо, урагшаа гүйж зээл, мөнгө хайх нь өр төлбөртэй, хүүнд нь живж буй эдийн засгийг бүр л намагт шигдүүлд орхино. Харамсалтай нь УИХ, Засгийн газар эдийн засагтаа бодитой хандаж чадахгүй байна. 2008 оноос хойш найман жил өнгөрлөө. Энэ хугацаанд хямралын олон үе шатаар монголчууд алхлаа. Зөв бодлого, дорвитой гарц хайхын оронд хямралаас гарах арга зам, зээл, бонд гэсэн үгийг хэлсээр өнөөдрийг хүрлээ. Эдийн засгаа өгөж татах цэгцтэй бодлого бид гаргаж чадсангүй. Процессыг хараад байхад төр барьж буй хүмүүсийн тархинд хуучны Гооллингоогийн пьез хийсэн аятай л байх юм. Нөгөө пьезаа л хийгээд, өнөөх дуугаа дуулах нь хэнд ч хэрэггүй. Төр барьж буй нам, гишүүд, эрх мэдэлтний харилцааны талаар ярих цаг нь аль эрт болоод байна. Энэ асуудлыг ярихгүйгээр бусад асуудлаа яриана гэдэг амаргүй, хэцүү зүйл. Эх орныхоо талаар ийм мэдээлэл сонсох үнэхээр хэцүү. Монгол Улс дампуурлын ирмэгт тулна гэж хэзээ ч би төсөөлж байсангүй. Яагаад ийм байдал хүрэв. Эрх барьсан энэ хоёр намын хуудуудтай, бодлоготой ажлын үр нь энэ. Үүнээс яаж гарах вэ, ямар арга зам байна вэ гэж олон хүн бодож бас асуудаг. Төрийн эрх мэдлээ танил тал , бүлэглэлийн эрх ашгийн төлөө ашигладаг хүмүүсийг сольж байж л бид хүнд байдлаас гарна. Төрийн толгойд авлигачид бөөс адил арзаганаж байгаа цагт бид

хөгжихгүй. Гэрэл гэгээтэй зүйл өнөөдөр хэлэхэд маш хэцүү. Улс орны эрх ашгийн төлөө ажиллах, зөв шийдвэр гаргах зүрх сэтгэл эрх баригчдад ус агаар мэт дутагдаж байна. Үндэсний төрт ёс, олон улсын геополитикийн орчин, монгол хүний сэтгэхүйн онцлог, ёс заншил, өв уламжлал, Монголын хөрсөнд буусан төрийн бодлого алга. Өөрөөр хэлбэл, Монголоо таньсан бодлого бидэнд үгүйлэгдэж байна. Монголчуудын ирээдүй, эрх ашгийг бид л өөрсдөө хамгаалж, бүтээн байгуулна гэдгийг сайн ойлгох хэрэгтэй.

### Л.Болд: АН-ын төлөв би дуустлаа явах болно

*/УИХ-ын гишүүн/*

Ардчилсан нам хувина хичээсэн, эрх мэдлийн төлөө яахаас ч буцахаа байсан, өөрийн номлолоор улайран дарангуйлах гэдэг цөөхөн хүний үйл хөдлөлөөс болж одоогийн хөшүүн байдалд орчихоод байна. Энэ нам Монгол төрийн тулгуур багануудын нэг гэдгийг хамгаасайн мэддэгдэгдэр нөхөд ялагдлаасаа, буруудлаасаа сургамж авч сэхээрэх, ухаарч эргэцүүлэх шинжгүй болоод удаж байна даа. Ардчилсан нам фракциудад хуваагдахад, тэд нь аливааг урагшуулахгүй мөргөлдөөд сөргөлдөөд байгаа гэдэг чинь зүгээр л нэг хий яриа шүү дээ. Жинхэнэ зөв бүтэцтэй, намын дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг фракци харин ч улс төрийн хүчний эрүүл төлөвшил, зөв хөгжилд нэмэртэй байх учиртай. Монголын төрийг дампууруулж, улс төрийг булингартуулж, эдийн засгийг сөхрөж байгаа нам дамжсан, улс төрийн бүлэглэл Монголд үүсээд бүх зүйлийг хянаж зохицуулж тохируулдаг болсон учраас АН ч ийм хөшүүн байдалд удаан хугацаагаар оршоор байна. Эцсийн бүлэгтээ, АН-ын ҮЗХ хурагдаж чадах уу, хуралдам ч өмнө тавьсан дэглэлт, зохиомжит захиалгаар хийгдэх үү эсрэг нь нэг их сонин биш юм. Хамгийн чухал нь энэ улс орныг хүнд байдлаас гаргаж, эдийн засгийн өсөлт, иргэдэд итгэл найдвар өгч чадах нам болох эсэхээ хэлэх учиртай

цаг үе юм. Нам ийм үгээ хэлэхгүй бол би ч бас байдлыг улам дордохыг, намаа үхширч ялзрахыг ажаад дуугүй байх сонирхолгүй байна. Монголын төлөө зүтгэх улстөрчийн замналыг албан ёсоор хоёр жилийн өмнө зарласан минь ч ийм учиртай. Улс төр бол миний амьдралын зам гэж зарласан нь цөөхөн дөө, ний нуугүй хэлэхэд. Ингэж хэлэх амаргүй шүү дээ. Ялагдал гэж байна, хэн ч биш болж гудамжинд лааз өшиглөж ч мэднэ шүү. Ялагдахаас үл айн улстөрч хэмээн зарласан амандаа хүрч эх орон, эгэл олны төлөө зүтгэдэг АН-ын төлөв би дуустлаа явах болно. Ерөөсөө АН өнөөдөр хүнээр бол хүнд өвчин тусчихсан хүлээн зөвшөөрч эрчимтэй, зөв эмчилгээ хийх хэрэгтэй байгаа юм. Түүнээс биш ном уншуулж, хоросол уух төдийнхөөр аргалаад илаар болчихгүй. Ингэж аргалаад хэвтрийн байдалд нь байлгаад байх сонирхолтой хүмүүс байгаа хэдий ч намын олон арван мянган гишүүд дэмжигчид маань эрүүл саруул, ирээдүйтэй, залуу намыг хүсэж байгаа. Улстөрчийн хувьд би шинэчлэл, хөгжил, дэвшил талд байнга дуугарч, хөдөлж тэмцэх болно. Надтай санал бодол, үзэл санаа нийлдэг олон арван хүмүүн бий гэдэгт гүнээ итгэдэг тул АН-аа муужралтын төлвөөс аварч чадна гэж бодож байна.

### Ж.Бат-Эрдэнэ: Долларын хиймлээр хөөрөгдөж байсан хөөс өөрийн эрхгүй дарагдлаа шүү дээ

*/УИХ-ын гишүүн/*

Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд маш их хэмжээний өр тавьсан. Векселийг шинээр гаргаж ирсэн бол концессоор маш их хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн байх жишээтэй. Тэртэй тэргүй төрийн захиалгаар ажил хийсэн компани, аж ахуйн нэгжүүдийн санхүүжилтийг зайлшгүй дарах л ёстой болчихоод байгаа юм. Өөрөөр хэлбэл, өмнөх Засгийн газрын тавьсан өрийг цэгцлэхээс аргагүй болчихоод

байна. Тэгэхээр одоо хуучин хөрөнгө оруулалтаа дуусгах, өмнө нь авсан өр зээлээ төлөх гэх мэт “цэвэрлэгээний” ажил л хийж байна. Ингэснээр эргээд төсвөө зөв голдиролд нь оруулж, сахилга батыг хангах шаардлага үүсч байгаа юм. Харин үүний дараагаар эдийн засгаа шинээр босгох бодлогыг л барьж таарна. Ерөнхийдөө ам.долларын нөөц буураад ирэхээр ханш нь өсдөг л дөө. Дээрээс нь зах зээлд ам.доллар орж ирэх бололцоо нь хаагдмал болчихоод байна. Гэхдээ бид зүгээр суугаагүй. Мөнгөний бодлогын хүрээнд ажлын хэсэг гаргаад ханшийг бууруулах талаар маш их ярьсан. Монголбанк болон Банкуудын холбоотой уулзаж ярилцсан. Эдийн засгийнхаа ном горимыг эвдээд ам.долларын өсөлтийг барина гэвэл бид өөрсдөө маш их хэмжээний ам.доллартай л байх шаардлагатай. Сүүлийн өдрүүдийн ам.долларын ханшийн өсөлт бол хөөсрөл. Цаанаасаа гадаад худалдаа ихсээд импорт хийх шаардлага одоогоор харагдахгүй болчихоод байгаа юм. Тэгэхээр хэрвээ импортын хэрэгцээ ихэсвэл ам.долларын эрэлт дагаж өсөх ёстой. Гэтэл импорт өсч өгөхгүй байна. Энэ бол ам.доллар хөөсөөр өссөний шинж. Суурь эдийн засгийнхаа үнэлгэн дээр хараад үзэхээр ам.долларын ханшийг барих гол зүйл нь орж ирж байгаа ам.доллар, нөгөө талдаа нөөц. Эдийн засгийнхаа өсөлтөөр ам.долларын ханш өсчихвөл түүнийг буулгахуйц хэмжээний нөөцтэй л байх хэрэгтэй. Жишээлбэл, БНХАУ бол сүүлийн хэдэн жил интервенц хийж, их хэмжээний нөөц нийлүүлж байх ханшийн өсөлтөө дарж ирсэн. Их хэмжээгээр нийлүүлээд эхлэхээр хүссэн хүсээгүй ханш нь буурдаг. Бид өнгөрсөн долоо хоногийн сүүлийн өдрүүдийн өсөлтөд тодорхой арга хэмжээ авсан. Тухайлбал, валютын ченжүүдэд нэлээд хяналт хийсэн. Мөн ченжийн зарчмаар ажиллаад байгаа банкуудын үйл ажиллагаанд ч хяналт тавьсан. Ингээд ирэхээр хиймлээр хөөрөгдөж байсан хөөс өөрийн эрхгүй дарагдлаа шүү дээ. Төсвийн сахилга батгүй байдлыг Олон улсын валютын сан хянадаг. Тэд биднийг хэт их зарлагаа бууруулахыг зөвлөж байгаа. Тэгэхээр бид “Стэнд бай” хөтөлбөрт зайлшгүй хамрагдах ёстой. Үүний хажуугаар төсөвтөө сахилга батыг бий болгох нь чухал. Олон улсын сахилга батгүй хөтөлбөрт хамрагдаад бодит нөхцөл байдлыг ард иргэддээ сайн танилцуулах хэрэгтэй байгаа юм. Ингэж байж зардлуудаа танахгүй бол буруу ойлголт түгэх магадлал өндөр шүү дээ. Харин цаашдаа валютын сангаасаа тусламж аваад явах нь зүйтэй. Эдийн засгийг халамжийн бус эргэлтэд оруулах нь л чухал байна.

Дугаарын **60** мөр

## Орон нутгийн замыг камержуулаач

**Үргэлжлэл.**  
**Түрүүч нь I нүүрт**

Сэхээ авах тэрхэн агшинд хажууд ёлох ээжийгээ бус, өвөр дээрээ тэвэрч явсан дөрөвхөн настай охиноо бэртээгүй байгаасай хэмээн залбирч, хамгийн түрүүнд л хөл гар, толгой тархи нь бүрэн бүтэн байгаа эсэхийг нягталсныхаа дараа л сэтгэл уужирч, бусад хүнийг анхаарах сөхөөтэй болсон доо. Азаар ч гэх юмуу, энэ ослоор ээж минь нуруугаа гэмтээснээс өөрөөр гэмтэж бэртсэн хүн байгаагүй. Үүнээс ч илүү аюултай байдалд орж болох байсныг бодож, ингээд өнгөрсөн нь зол хэмээн одоо сэтгэж сууна. “Хүн хэлэхээс нааш ойлгохгүй, цаас чичихээс нааш доорохгүй” гэх үг байдаг даа. Ер нь жолооч нар орон нутгийн замд гарахдаа хурд хэтрүүлсэнээс болж, маш олон хүний ам үрэгдсэн байдаг юм билээ. Саяхан албаныхан сэтгэл сэрэхийгэм тоо баримтыг олон нийтэд хүргэсэн юм. Сүүлийн таван жилийн байдлаар улсын хэмжээнд хүүхэд өртсөн зам тээврийн осол 5446 бүртгэгдэж, 5611 хүүхэд өртсөнөөс 222 нь амиа алдсан байх жишээтэй. Үүний 44 нь нийслэлд гарсан ослоор амь үрэгдсэн бол 178 нь хөдөө, орон нутагт гарсан зам тээврийн ослоор хорвоог орхисон байх юм. Тэгвэл зөвхөн өнгөрөгч аравдугаар сарын байдлаар гэхэд улсын хэмжээнд 48 хүүхэд зам тээврийн ослын улмаас нас барсан байх бөгөөд үүний 43 нь орон нутагт гарсан ослоор амь үрэгдсэн байна. Ерөнхийдөө нийслэлээс илүүтэйгээр орон нутагт осол аваар их гардаг гэдгийн нотолгоо нь энэ тоон баримтаас харагдаж байна. Хүн ам олноор суурьшсан, харьцангуй хяналт сайтай учир нийслэлд хүүхэд амь үрэгдэх хэмжээний томоохон осол гарах нь орон нутгийг бодвол бага бололтой. Тиймээс орон нутгийн замд анхаарал хандуулаач гэж холбогдох албаныхнаас хүсмээр байна. Авто осол ихээр гардаг зам дээр 30 км тутамд анхааруулах самбар байрлуулж, постуудын тоог нэмэгдүүлэн, хурд хэмжигч байрлуулвал ямар вэ. Хэрэв боломжтой бол хяналтын камер ч байрлуулж болох биш үү. Гарч буй ослын байдлаас харахад ихэвчлэн төв шулуун аймгуудыг дайран өнгөрдөг зам дээр осол их гардаг аж. Тухайлбал, Сэлэнгэ, Төв, Хэнтий, Баянхонгор, Орхон аймагт гарч байгаа хэргийн тоо нь бусад аймгаас өндөр байдаг юм. Нарийхан зам дээр хурд хэтрүүлж давхидга нь орон нутгийн замд зам тээврийн осол хэрэг гарах гол шалтгааны нэг болдог аж. Үүнээс гадна байнгын хяналт шалгалтгүй нь ч осол гарах нэг үндэс болдог байна. Тиймээс замын цагдаа байнга хянаж чадахгүйгээс хойш камержуулж, бүр болдоггүй юм аа гэхэд анхааруулах самбар, постынхоо тоог нэмбэл яасан юм. Ер нь ч тэгээд, хотод түгжирч явсан жолооч нар орон нутгийн замд гарахаараа уяанаасаа алдуурсан нохой мэт төмөр хүлгийн хурд мэдэн давхидга нь нууц биш. Аваар осол гэдэг хэнд ч тохиолдож болно. Суудлын жижиг машинд зургаан хүн зорчж явлаа гэхэд, тэнд буй хүмүүсийн амь насыг зөвхөн жолооч л хүрдэн дээр тавьсан гартаа атгаж явдаг шүү дээ. Тиймээс жолоо барьж буй хүмүүс өөрсдөө анхаарал болгоомжтой байж, ослоос урьдчилан сэргийлэхээс гадна орон нутгийн удирдлага, төр засгаас ч гэсэн боломжит хувилбараар орон нутгийн замд анхаарал хандуулах хэрэгтэй байна. Зөвхөн нийслэл дэх автозамд хяналт тавьж, анхаарсаар байх зуурт тань орон нутгийн замд бидний хойч ирээдүй болсон бяцхан үрс хорвоогоос буцсаар байна, эрхмүүд ээ.

## АШИГЛАЛТЫН ТУСТАЙ ЗӨВШӨӨРӨЛ ЭЗЭМШИГЧИД БОЛОН БАЯЖУУЛАХ, БОЛОВСРУУЛАХ ҮЙЛДВЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭГЧДИЙН АНХААРАЛД

“Ашигт малтмалын тухай хууль”-ийн 48.6 дугаар зүйл, Ашигт малтмал, газрын тосны газрын даргын 2016 оны а/22 дугаар тушаалаар батлагдсан “Хайгуулын болон Ашигт малтмал ашиглах үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, мэдээ хүлээн авах заавар”-ын дагуу 2017 оны Ашигт малтмал ашиглах, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Ашигт малтмал ашиглах, үйл ажиллагааны төлөвлөгөөг цахим хэлбэрээр info.rp.mn.gov.mn хаягаар ирүүлэх ба “ЦАХИМ СИСТЕМА НЭВТРЭХ ЭРХ”-ийг АМГТГ-ын холбогдох хэлтэст албан бичгээр хандаж авахыг анхааруулья.

Дээрх зааврыг Ашигт малтмал, газрын тосны газрын цахим хуудас болох www.mnam.gov.mn сайтад хандаж татаж авна уу.

**Ашигт малтмал, газрын тосны газар**  
**2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр**

### ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## АМГТГ БНСУ-ЫН ТАЛТАЙ ТУРШЛАГА СОЛИЛЦЛОО

**Үргэлжлэл.**  
**Түрүүч нь I нүүрт**

Нийслэлийн агаарын бохирдлын 10 хувийг автомашинаас ялгаруулж буй хорт утаа эзэлж буйг мэргэжлийн байгууллагаас тогтоосон байдаг. Тэгвэл АМГТГ агаарын бохирдлыг багасгах, хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах ажлын хүрээнд Улаанбаатар хот болон томоохон хотуудад ирэх оны аравдугаар сараас эхлэн евро-4 стандартаас дээш чанарын шаардлага хангасан шатахуун хэрэглэх зорилт тавин ажиллаж буй аж. Улмаар энэ хүрээнд хууль эрхзүйн орчныг боловсронгуй болгох, шатахууны стандартуудыг шинэчлэн батлуулах, газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтын тогтолцоог сайжруулах, лабораторийн тоног төхөөрөмжийн хүчин чадал, үйл ажиллагааг нэмэгдүүлэх, боловсон хүчнээ чадваржуулах чиглэлээр БНСУ-ын КПетро газрын тосны газартай хамтран ажиллах санаж бичиг байгуулахаар ярилцаж байгаа юм байна. Хэлэлцүүлгийн үеэр тус үйл ажиллагааг зохион байгуулж буй АМГТГ-ын Газрын тосны бүтээгдэхүүний хэлтсийн дарга Б.Бямбацогтоос цөөн асуулт асуулаа.

### Б.Бямбацогт: Мэргэжилтэн солилцох, тоног төхөөрөмж нийлүүлэх талаар ярьж тохирлоо

“Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналт” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж байна. Энэ талаар мэдээлэл өгөөч?

Газрын тосны чанарын хяналттай холбоотойгоор К Петро буюу БНСУ-ын Газрын тосны газрын орлогч дарга, төлөвлөлт хяналт шалгалт хариуцсан дарга нарын хүмүүс манайд улсад хүрэлцэн ирж, “Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналт” сэдэвт туршлага солилцох хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Энэ удаагийн туршлага солилцох хэлэлцүүлэг анх удаагаа мэргэжлийн болоод ТББ-ууд, ассоциаци, мэргэжлийн холбоодын төлөөлөл гэх мэт салбарын бүхий л төлөөллийг оролцуулж байгаа гэдгээрээ өндөр ач холбогдолтой болж байна. К Петро газрын тосны газартай манай АМГТГ-ын зүгээс хамтран ажиллах санаж бичиг байгуулах асуудлыг маргааш /өнөөдөр/ хэлэлцэнэ. Түүнчлэн газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтыг сайжруулах чиглэлээр

К Петрогийн зүгээс манайд туслах, харилцан мэргэжилтнээ солилцох, лабораторийн тоног төхөөрөмж нийлүүлэх талаар ч гэсэн хэлэлцүүлгийн үеэр ярьж тохирлоо.

Газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтыг сайжруулснаар ямар ач холбогдолтой вэ?

Манай улсын тулгамдсан асуудлын нэг бол яах аргагүй газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналт юм. Манайх дотоодын хэрэгцээгээ 100 хувь импортын бүтээгдэхүүнээр хангадаг. 90 орчим хувийг нь ОХУ-аас, үлдсэн 10 хувийг нь БНХАУ, БНСУ-аас импортлож байгаа. Харин импортын энэ мэт газрын тосны бүтээгдэхүүний чанарын хяналтыг сайжруулснаар стратегийн өндөр ач холбогдолтой чухал алхам болох юм. Тиймээс үүнд анхаарал хандуулж, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах чиглэлээр манай хэлтэс болоод агентлагийн зүгээс хэрэглэгчид, холбогдох байгууллагын төлөөлөлтэй хамтран ажиллах зорилт тавьж байна.

Одоогоор газрын тосны бүтээгдэхүүний чанарт хэрхэн хяналт тавьж байгаа вэ. Энэ талаар манай уншигчдад товч мэдээлэл өгөхгүй юу?

Хуучин Газрын тосны газар гэж байхад Чанарын хяналтын

лаборатори баригдсан шүү дээ. Тэнд хилээр орж буй газрын тосны бүтээгдэхүүнтэй холбоотой хэрэглэгчдийн санал гомдлыг барагдуулах зорилгоор чанарын үнэлгээ хийж, баталгаажуулах ажил хийгддэг.

Мөн шаардлагатай тохнолдолд лабораторийн цүнхэн багажийг ашиглан газар дээр нь очиж, хэрэглэгчдийн санал гомдлыг барагдуулан ажилладаг юм. Үндэсний хэмжээнд газрын тосны бүтээгдэхүүний чанарыг хэмждэг нэг л лаборатори байдаг. Лаборатори маань хамгийн сүүлийн үеийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон гэдгийг хэлэх хэрэгтэй болов уу.

БНСУ-аас тоног төхөөрөмж нийлүүлэх талаар та дурьдсан. Хэзээ орж ирэх вэ?

Ирэх арванхоёрдугаар сард тоног төхөөрөмжийг манайд нийлүүлнэ. Ерөнхийдөө гурван төрлийн тоног төхөөрөмж ирэх юм. Газрын тосны бүтээгдэхүүний чанар стандартад нийцэж буй эсэхийг тогтоох төхөөрөмжөөс гадна дизель түлшний өвөл, зуны хэмжээнд нийцэж буйг, мөн өөр компаниас нийлүүлж буй бусад бүтээгдэхүүний чанарыг хэмжих хүчин чадалтай тоног төхөөрөмжүүд ирнэ. Ингэснээр бүтээгдэхүүний чанарын асуудалд томоохон дэвшил гарна гэж харж байна.

# ДЭЛХИЙ

## АПЕК-аар 11500 цагдаа бэлэн байдалд ажиллана

Перугийн Лима хотод энэ сарын 20-ныг хүртэл Ази, номхон далайн орнуудын эдийн засгийн хамтын ажиллагааны чуулга уулзалт зохион байгуулагдах билээ. Чуулга уулзалт очигдөр албан ёсоор эхэлсэн юм. Улмаар уулзалтын хүрээнд Ази, номхон далайн орнуудын төрийн тэргүүн, Засгийн газрын өндөр дээд албан тушаалтнууд Лима хотноо хурал цугларсан бөгөөд энэхүү үйл явдлыг тохиолдуулан тэдний аюулгүй байдлыг хангах үүднээс 11500 цагдаагийн алба хаагч бэлэн байдалд ажиллаж буй талаар эх сурвалжууд мэдээллээ. Түүнчлэн, чуулга уулзалт болох газруудын ойролцоох

автозамыг хаах арга хэмжээ авах зэргээр өндөржүүлсэн бэлэн байдалд ажиллах ажээ. АНУ, БНХАУ, Япон гэх мэт дэлхийн 21 улс, бүс нутгийн холбогдох албан тушаалтнуудын АПЕК-ын уулзалтыг зохион байгуулагч гэдэг утгаараа Перу удирдах бөгөөд энэ нь 2008 оноос хойш хоёр дахь удаагаа болж байна. Уулзалтад Японы Ерөнхий сайд Шинзо Абэ, АНУ-ын Ерөнхийлөгч Барак Обама, ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путин, БНХАУ-ын дарга Си Зиньпин нараас гадна фэйсбүүкийн гүйцэтгэх захирал Марк Зукерберг нарын санхүүгийн салбарынхан тэргүүтэй 8000 орчим хүн Перуд иржээ.

## БНСУ-ын 606 мянган элсэгч шалгалтаа өглөө

Хэт өрсөлдөөнт нийгэмтэй гэгддэг БНСУ-д очигдөр ахлах сургуулийн сурагчдын элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулагдаж, 600 гаруй мянган ахлах ангийн сурагчид ирээдүйгээ шийдвэрлэх хүндхэн шалгалтынхаа ард гарчээ. Элсэлтийн ерөнхий шалгалт гэдэг ахлах сургуулийн сурагчид болоод тэдний гэр бүлийнхний хувьд тун чухал өдөр юм. Шалгалт өглөөний 8:30 цагаас оройн 17.40 минут хүртэл үргэлжилсэн бөгөөд энэ жилийн шалгалтыг 606 мянган хүүхэд өгчээ. Энэ хооронд гэд солонгос хэл, математик, англи хэл, нийгмийн болон байгалийн шинжлэх ухаан, хоёр дахь хэлний шалгалтуудыг дундаа завсарлагатайгаар

дараалуулан өгч буй аж. Энэ жилээс эхлэн сурагчид Солонгосын түүхийн шалгалтыг заавал өгдөг болсон байна. Амьдралыг нь шийдвэрлэх анхны алхам гэдэг утгаар нь төр засгийн хэмжээнд ч бодлогоор зохицуулалт хийж, улс орон даяар элсэгчдийг шалгалтаас хоцруулахгүйн тулд Засгийн газрын байгууллагууд, томоохон компаниудын ихэнх нь ажил эхлэх цагаа өөрчилж, зах зээл ч энгийн үеэсээ нэг цагаар хоцорч нээдэг байна. Үүнээс гадна шалгалт авч буй байрны ойролцоох автозамаар том оврын ачааны машин явахыг хориглохоос гадна үйлдвэрүүдийн үйл ажиллагааг ч түр хугацаанд зогсоодог ажээ.

## Шведийн төв банк цахим валют гаргана

Шведийн төв банк болох "Рикс" тусгай цахим валют гаргахаар судалж эхэлжээ. Тэд ойрын хоёр жилдээ багтаан тус валютаа гаргахаар төлөвлөж байгаа юм байна. Дэлхийн хамгийн эртний төв банк гэгддэг Рикс банкны орлогч дарга Сесилиа Скнингслий нийслэл Стокгольм хотод тавьсан илтгэлийнхээ үеэр энэ талаар дүрсчээ. Тэрбээр "Рикс банк бэлэн мөнгөтэй адил цахим төлбөрийн хэрэгслийг нэвтрүүлэх хэрэгтэй байна"

хэмээсэн байна. Гэхдээ ингэхийн тулд технологи, хууль эрх зүйн асуудлыг шийдвэрлэх шаардлага гарах бөгөөд Рикс банк төв банк гэдэг утгаараа дэлхийн хамгийн анхны электрон валютыг гаргах эсэх нь одоогоор тодорхойгүй байгаа юм. Сесилиа Скнингслий "Электрон валют гаргах ажил бидний төсөөлснөөс амаргүй байж мэднэ. Учир нь бидэнд жишиг байхгүй. Тиймээс манай төв банкны хийх үйл ажиллагаа бүгд шинэ оролдлого байх

болно" гэжээ. Гэхдээ электрон валют гаргах саналыг ганц Шведийн төв банк гаргасан юм биш. Өмнө нь Английн төв банк, Канадын төв банк ч гэсэн энэ асуудлыг хэлэлцэж эхэлсэн гэнэ. Рикс банкныхны хэлж буйгаар хүн амынх нь 97 хувь нь банкны кредит карт ашигладаг Шведэд сүүлийн таван жилийн хугацаанд бэлэн мөнгөний гүйлгээ тодорхой хувиар багасчээ. Харин кредит карт ашиглалт ойролцоогоор 50 хувиар нэмэгдсэн байна.

## Энэтхэгийн алтны магнат охиныхоо хуримд зориулж, хааны ордон түрээсэлжээ



Том дүнтэй мөнгөн тэмдэгтүүдээ гүйлгээнээс хасч, оронд нь шинэ дэвсгэртэйг нэвтрүүлснээр эмх замбараагүй байдал үүсээд буй Энэтхэгийн алтны магнат Гали Жанардхан Редди охиныхоо хуримд зориулан хааны ордон түрээсэлж, Бразилиас бүжигчин урьж авчирчээ. Ганц охиныхоо хуримыг дэлхийн баячуудаас дутахааргүй зохион байгуулсан алтны магнат эр дээрх бүх зардалд нийтдээ 75 сая ам.доллар зарцуулсан гэнэ. Түүний түрээсэлсэн Бангалоре ордонд 50 мянган зочид Хинди шашны хууль журмын дагуу хуримын ёслолоо зохион байгуулсан Реддигийн охинд баяр хүргэхээр цугларсан байна. Орон нутгийн зарим мэдээллийн сайтуудын дамжуулж буйгаар Засгийн газрын том дүн бүхий мөнгөн дэвсгэртэйг гүйлгээнээс хасах шийдвэр гаргасантай холбоотойгоор жирийн

маш олон иргэд идэх хоолоо худалдан авч чадахгүйд хүрч байхад, эсрэгээр алтны магнат охиныхоо хуримд сая сая ам.доллар цацсан нь иргэдийн эгдүүцлийг төрүүлээд буй гэнэ. Нөгөөтэйгүүр, Энэтхэгийн алтны магнат Гали Жанардхан Редди ганц охинтой бөгөөд түүнийхээ амьдралд мартагдашгүй дурсамж үлдээхийн тулд ийнхүү нүсэр хуримын ёслолыг зохион байгуулсан хэмээн түүний ойрын эх сурвалжууд тайлбарлажээ.

## Б.ДАВААХҮҮ

АНУ-ын ээлжит Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшээд өвдөг шороодсон Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон улс төрийн туршлагагүй нялх улстөрч гэгддэг үл хөдлөх хөрөнгийн бизнесмэн эрд ялагдсанаас хойш анх удаагаа олны өмнө гарч, мэдэгдэл хийлээ. Тэрбээр мэдэгдлийнхээ үеэр "Дэлхийн хамгийн том гүрний гүн гүнзгий хагарал сонгуулиар ил болсон хэмээн онцолсон байна. Хиллари Клинтон Вашингтон ДС хотод зохион байгуулагдсан тусламж нэн шаардлагатай байгаа хүүхдийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулах "Children's Defense Fund" ашгийн бус байгууллагын үйл

ажиллагаанд оролцжээ. Улмаар үйл ажиллагаанд нь оролцохоор хүрэлцэн ирсэн хэдэн зуун хүний өмнө гарч, үг хэлсэн байна. Ингэхдээ "Өнгөрсөн долоо хоногийн хугацаанд маш олон хүн Америк орон өөрсдийнх нь бодож байсан шиг тийм улс мөн эсэхийг өөрсдөөсөө асуулаа" хэмээжээ. Мөн үргэлжлүүлэн "Энэ удаагийн сонгуулийн кампанит ажлын үеэр ил болсон хагарал үнэхээр гүн гүнзгий байгаа ч, та бүхнийг сонсоосой гэж хүсч байна. АНУ-д өөрийн гэсэн үнэ цэнэ гэж бий. Өнөөдөр энэ танхимд ирэх миний хувьд тийм амар байгаагүй. Өнгөрсөн долоо хоногийг би ном уншиж, ноходтойгоо хамт унтаж л өнгөрүүлээ. Яагаад ч юм дахин гэрээсээ гармааргүй тийм сонин мэдрэмж надад хэд хэдэн удаа төрсөн" гэжээ. Мөн тэрбээр энэ

үеэр Доналд Трампын нэрийг хэдийгээр дурьдаагүй боловч, сонгуулийн сурталчилгааны үеэр хууль бус цагаачдын хүчээр нутаг буцаана гэх түүний амлалтаас иш татаж, "Хүүхдүүд ч гэсэн айж байна. Тухайлбал, Невада мужид надтай тааралдсан бяцхан охин эцэг эхийг нь энэ улсаас хүчээр гаргахыг вий гэдгээс айж байгаагаа хэлээд уйлж билээ. Ийм байдалтай айдас хүйдэс дунд хүүхэд байх ёсгүй" гэсэн байна. АНУ-ын Төрийн нарийн бичгийн даргаар ажиллаж байсан туршлагатай, эдийн засагчид, улс төрийн салбарынхан, урлаг соёлынхон гээд бараг бүхий л салбарынхны дэмжлэгийг хүлээж байсан Хиллари Клинтон энэ сарын 8-нд болсон сонгуулиар төлөөлөгчдийн саналаар ялагдал хүлээсэн юм. Гэхдээ тэрбээр

сонгогчдоос авсан саналын тоогоороо тэргүүлж байсан удаатай. Тодруулбал, Хиллари Доналд Трампаас нэг саяар илүү санал авсан ч, төлөөлөгчдийн саналаар ялагджээ. Урьдчилсан байдлаар Хиллари Клинтон төлөө Америкийн 61 сая 963 мянга, 234 сонгогч саналаа өгсөн бол Доналд Трампын төлөө саналаа өгсөн сонгогчийн тоо 60 сая 961 мянга 185 байсан аж. Ардчиллын орон гэгддэг америкчууд Ерөнхийлөгчөө шууд санал хураалтаар сонгодоггүй бөгөөд сонгогчдын төлөөллийн саналаар сонгогддог билээ. Ямартай ч, сонгогчдынхоо тоогоор Трампыг тэргүүлсэн ч, төлөөлөгчдийн саналаар ялагдсан Хиллари Клинтон сонгуулийн дараах долоо хоногийг тун хүндхэн байдлаар өнгөрүүлж буй бололтой.

## №4 ТАНЫ ТӨЛСӨН НИЙГМИЙН ДААТГАЛЫН МӨНГӨ ЮУНД ЗАРЦУУЛАГДАД ВЭ



Манай сонин долоо хоног бүрийн баасан гарагт нийгмийн даатгалын үйлчилгээ, түүний талаархи түгээмэл асуулт хариулын буланг Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага /ЖАЙКА/-ын Монгол Улсад хэрэгжүүлж буй Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн мэргэжилтнүүдтэй хамтран бэлтгэн хүргэж байгаа билээ. Уншигчдын төдийлөн мэддэггүй ч, заавал мэдэж байх ёстой түгээмэл асуултад Нийгмийн даатгалын үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх төслийн ахлах зөвлөх Ямашита Мамору хариулж байна.

### -Японд залуусын төлсөн нийгмийн даатгалын мөнгө хэрхэн зарцуулагддаг вэ?

-Японд тэтгэврийг зөвхөн өндөр настанд олгогддог тэтгэмж л гэж ойлгодог. Гэхдээ тийм биш. Тэтгэвэр бол "Даатгал" юм. Энэ үүднээс ямарваа нэг эрсдэл тохиолдсон хүнд олгогдох нөхцөлтэй байдаг. Эрсдэлд нэгдүгээрт, өндөр наслах, хоёрдугаарт өвдөх буюу бэртэх гэмтэх, гуравдугаарт нас барах багтана. Энэ мэт эрсдэлээс шалтгаалан өрхийн орлого багасгах бөгөөд яг энэ үед нь тэтгэвэрээр дамжуулан тодорхой хэмжээнд дэмжих үүргийг тэтгэврийн тогтолцоо үүрнэ гэж ойлгож болно. Тэгэхээр тэтгэвэр гэдэг цор ганц өндөр настнуудад зориулсан тэтгэмж биш байх нь. Залуус ч гэсэн зам тээврийн осол орж, эсвэл өвчин тусч болно шүү дээ. Иймэрхүү эрсдэлээс шалтгаалан ямар нэг байдлаар орлого багассан үед нөхөн олговор авах боломжтой гэсэн үг. Залуус гэлтгүй бид бүгдийн төлж буй даатгалын мөнгө өвчин, осол гэмтэл, нас барах гэх мэт саар зүйл тохиолдсон хэн нэгэнд дэмжлэг болдог юм. Тэр хэн нэгэн гэдэгт та бүхэн өөрсдөө ч багтаж болохыг ойлгоосой гэж хүсч байна.

Шинэ Монгол бүрэн дунд сургуулийн ахлах ангийн сурагчдад Жайка төслийн ахлах зөвлөх "Нийгмийн даатгалын ач холбогдол болон Японы тэтгэврийн даатгалын тогтолцооны үүсэл хөгжил"-ийн талаар лекци уншлаа

# СПОРТ

АРГЕНТИН ЧАНСААГАА ХАДГАЛЖ, ОРОС АНТИ РЕКОРД ТОГТООЛОО

VI нүүрт

Г.ОТГОНЦЭЦЭГ КАЗАХСТАНЫ АВАРГА БОЛЛОО

VII нүүрт



ЯРИЛЦАХ ТАНХИМ



## Э.Одонцэцэг:

Н.ПУНЦАГБОЛД

*Хан-Уул дүүрэг дэх цагдаагийн II хэлтсийн Нийтийн хэв журам хамгаалах тасгийн эргүүлийн цагдаа, Цагдаагийн ахлагч Э.Одонцэцэгтэй ярилцлаа. Тэрбээр Монголын Үндэсний Сагсан бөмбөгийн холбооны элэгтэй дээд лигийн Үндэсний биений талифын дээд сургуулийн "Best Cashmer" багийн тоглогч юм.*

**-Цэрэг, цагдаагийн байгууллагуудад олон алдартай тамирчид харьяалагдаж, ажилладаг. Таны хувьд цагдаагийн байгууллагад хэзээ орж, ажиллаж эхэлсэн бэ?**  
-Анх 2012 онд цагдаагийн байгууллагад орж, ажиллаж эхэлсэн. Тухайн үед би ШУГИС-ийн оюутнуудаас бүрдсэн "Хөвсгөл нэг үе" багт тоглодог байлаа. Тэр үедээ л "Хүч" спорт хорооны нэр дээрээс тэмцээнд оролцсон юм. Гэтэл тэмцээний дараа цагдаагийн байгууллагад үлдэж ажиллах хүсэлтэй байвал саналаараа орж болно шүү гэсэн.

Төгсгөл нь VII нүүрт

## ЦАГДААГИЙН АЖИЛ ЗАВ БАГАТАЙ Ч БЭЛТГЭЛЭЭ ТАСРАЛТГҮЙ ХИЙЖ, УР ЧАДВАРАА БУУРУУЛАХГҮЙГ ХИЧЭЭДЭГ

Гэрэл зургийг Г.АРИУУЖИН

### О.Пүрэвбаатарын нэрэмжит тэмцээний аваргууд тодорлоо

ДАШТ-ий хошой мөнгөн медальт, "Дэлхийн цом"-ын төлөө тэмцээний хүрэл медальт, Азийн наадмын болон тивийн аварга, гавьяат тамирчин О.Пүрэвбаатарын нэрэмжит залуучуудын тэмцээн өнгөрсөн мягар гарат боллоо. Тэрбээр тэмцээний өмнө "Рио-2016" олимпын наадмын

циклд мөр зэрэгцэн амжилтад хүрсэн эрэгтэй шигшээ багийн дасгалжуулагч Ц.Цогтбаяр, Л.Энхбаяр, Б.Баяраа нартаа мөн дурсгалын зүйлс гардуулсан юм. Мөн дэлхийн аваргын мөнгөн медальт Б.Номин тэргүүтэй шавь нар болон 2012-2016 оны чөлөөт бөхийн эрэгтэй шигшээ багийн хамт олон

О.Пүрэвбаатар багшдаа хүндэтгэл үзүүлсэн билээ. Тэмцээнд оролцох бөхчүүд Дэлхийн бөхийн нэгдсэн холбооны залуучуудын хөнгөн жингийн ангиллаар жинд аваргаа тодруулсан юм. Тэгвэл 50кг-д Н.Насанбуян, 55кг-д Цогбадрах, 60кг-д Т.Тулга, 66кг-д Х.Хишигбат нар түрүүллээ.

### Спорт холбоодын хэлэлцүүлэг боллоо

БСШУСЯ-ны харьяа Биений тамир, спортын газрын Спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсээс сар бүрийн гурав дахь долоо хоногт Монголын спорт холбоодын ерөнхий нарийн бичгийн дарга нартай уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулдаг билээ. Энэхүү уулзалт нь төр болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулахад чиглэдэг юм. Анхны хэлэлцүүлэг өнгөрсөн сарын 12-нд болж, Монголын нийт 74 спорт холбоодоос 52 нь оролцож байв. Тэгвэл энэ удаагийн хэлэлцүүлгээр спорт холбоодын улсын төсвийн хөрөнгөөр улсын аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулах эрх олгох шалгуур үзүүлэлтийн төсөл дээр спорт холбоодын саналыг хүлээн авлаа. Тус хэлэлцүүлгийг БТСГ-ын Спортын бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтсийн дарга Х.Бакытжан удирдан явуулсан юм.

### Дэлхийн 50 орны тамирчин хүүхдүүд Монголд цуглана

"Азийн хүүхдүүд" олон улсын хүүхдийн спортын УШ наадмыг 2020 онд Монгол Улсад зохион байгуулна. Тэмцээний зохион байгуулалт, арга хэмжээний зардалд зургаан тэрбум төгрөг төсөвлөсөн бөгөөд үүний 60 хувийг улс, орон

нутгийн төсвөөс, үлдсэн 40 хувийг ивээн тэтгэгчид болон олон улсын байгууллагаас бүрдүүлнэ гэж тооцжээ. Энэ наадамд 45-50 орны 3000 гаруй тамирчин, 500-гаад дасгалжуулагч, 90 шүүгч, албаны 120-нод төлөөлөгч ирнэ гэсэн урьдчилсан тооцоо

гараад байна. Олон улсын нэр хүнд бүхий наадмын бэлтгэлийг хангах, холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газраас Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ж.Батсуурьт үүрэг болгожээ.



МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

### Футзалын УАШТ-ий сугалааг татлаа

Монголын Хөлбөмбөгийн Холбооноос зохион байгуулдаг футзалын хамгийн том хоёр тэмцээний нэг болох Футзалын УАШТ-ий сугалаа сугалах ёслолын үйл ажиллагаа өчигдөр боллоо. Эхний гуравт орсон баг "Пепси" футзалын дээд лигт дэвших зарчимтай тус тэмцээнд 27 багийн 300 гаруй шилдэг тамирчид өрсөлдөхөөр болсон. Эдгээр багууд А, В, С, D, E, F, G гэсэн долоон хэсэгт хуваагдахад G хэсэгт гурван баг хуваарилагджээ. Ирэх долоо хоногийн бямба гаригт эхлэх ФУАШТ-нд хөдөө орон нутгаас Дорнод, Баянхонгор, Төв, аймгийн шигшээ багууд болон Дархан-Уул аймгийн "Дархан шилүүс" клуб оролцох юм байна.

- В хэсэг:**
1. Дорнод
  2. Сонгинохайрхан
  3. Атлетик 220
  4. Дарханшилүүс
- С хэсэг:**
1. Төв
  2. ХАД
  3. Алтгус Лионс
  4. Хараацай
- Д хэсэг:**
1. Төрийн банк
  2. Титан
  3. Баянхонгор
  4. Улаанбаатар сити
- Е хэсэг:**
1. Тиганнум
  2. Мэжик фүүт
  3. ЖИПРО
  4. Леженд
- Г хэсэг:**
1. Бешикташ
  2. Эрчим
  3. Бумаасанаа
  4. Туулын Том Тулнууд
- А хэсэг:**
1. Гоёо
  2. Докторс
  3. МУБИС
  4. Монголын Тэмүүлэл

### Шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээн маргааш эхэлнэ



Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ой 2017 оны нэгдүгээр сарын 13-нд тохиох юм. Тэгвэл Үндсэн хуулийн ойн хүрээнд улс орон даяар шатар сонирхогчдын улсын аварга шалгаруулах тэмцээнийг уламжлал ёсоор зохион байгуулах гэж байна. Энэ жилийн тэмцээн маргааш орон даяар Монгол Улсын бүх сум, нийслэлийн дүүргүүдэд эхлэх юм. УИХ-ын дарга М.Энхболдын ивээл дор болох энэхүү тэмцээн оролцохыг хүссэн хүн бүхэнд нээлттэй юм. Тэмцээн гурван үе шаттай болно. Энэ сарын 19-20-ны өдрүүдэд анхан шатны тэмцээн болох бол ирэх сарын 10-11-нд хагас шигшээ буюу аймаг, нийслэлийн аварга шалгаруулах тэмцээн болох юм. Тэгвэл шигшээ буюу улсын аварга шалгаруулах тэмцээн 2017 оны нэгдүгээр сарын 7-8-нд болох ажээ. Шигшээ тэмцээн Төрийн ордонд болох бөгөөд хагас шигшээгээс шалгарсан шатарчид болон УИХ, Үндсэн хууль тогтоогчдын холбоо, УИХ-д ажлаа тайлагнадаг буюу Их хурлаас томилогддог байгууллагын шатарчид буюу нийт 120 орчим шатарчин өрсөлдөж, аваргаа тодруулах юм байна. Түрүүлсэн эрэгтэй, эмэгтэй шатарчид Спортын дэд мастер цол олгох ажээ.

### "Алтан гран-при" тэмцээнд манай 11 бөх уригджээ

Азербайжан улсын нийслэл Баку хотын "Baku Sport Hall" спортын ордонд энэ сарын 24-26-ний өдрүүдэд Г.Алиевийн дурсгалд зориулсан чөлөөт бөхийн "Голден Гран-При" олон улсын уламжлалт тэмцээн гурван төрлөөр болно. Х дахь удаа болж байгаа энэхүү олон улсын тэмцээнд манай улсаас эрэгтэй чөлөөт бөхийн төрөлд долоо, эмэгтэй чөлөөт бөхийн төрөлд дөрөв нийт 11 бөх уригджээ. Тухайлбал эрэгтэй чөлөөт бөхийн төрөлд 57 кг-ын жинд С.Батболд, 61

кг-ын жинд Т.Түвшинтулга, 65 кг-ын жинд Б.Батмагнай, 70 кг-ын жинд Б.Батзориг, 86-ын жинд О.Үйтүмэн, 97 кг-ын жинд Д.Хүдэрбулга, 125 кг-ын жинд Н.Золбоо нар оролцох юм. Харин эмэгтэй чөлөөт бөхийн төрөлд 55 кг-ын жинд Д.Отгонцэцэг, 58 кг-ын жинд Э.Гантуяа, 60 кг-ын жинд О.Оюунтуяа, 69 кг-ын жинд З.Болортунгагал нар уригдсан байна. Уригдсан бөхийн оронд тухайн орноос өөр бөх барилдуулж болох ажээ.



## СПОРТ

# Аргентин чансаагаа хадгалж, ОРОС АНТИ РЕКОРД ТОГТООЛОО

Н.ПУНЦАГБОЛД

Олон улсын хөлбөмбөгийн холбоо шигшээ багуудын чансааг арваннэгдүгээр сарын байдлаар шинэчлэн гаргажээ. Гэхдээ шинэчилсэн чансааг энэ сарын 24-ний өдөр зарлах юм байна. Тэгвэл Оросын "Sports.ru" спортын сайт урьдчилсан байдлаар шинэчилсэн чансааны мэдээг түгээсэн юм. Шинэ чансаа ёсоор Аргентин тэргүүн байраа хадгалж үлдсэн бол Бразил гуравдугаар байраа ахиулж, хоёр руу орж иржээ. Харин Германы шигшээ хоёрдугаар байрнаас гурав руу унасан байна.

Сүүлийн үед тун амжилттай байгаа Чилийн шигшээ багийн хувьд чансаагаа огцом

дээшлүүлж, зургадугаар байрнаас дөрөв рүү орж ирж байгаа юм байна. Чилийн шигшээ сүүлийн хоёр жил дараалж "Копа Америка" тэмцээнд түрүүлсэн юм. Мөн дэлхийн аваргын урьдчилсан шатанд ч тун амжилттай тоглож байгаа. Хамгийн сүүлд гэхэд Өмнөд Америкийн бүсэд Уругвайн шигшээ багийг буулгаж авсан билээ. Тэгвэл нэг хэсэг дэлхийн чансааг өнгөлж байсан Бельгийн шигшээ багийн хувьд дөрөвдүгээр байрнаас тав руу унаж байгаа ажээ. Тэгвэл сүүлийн үед тун ч тааруу байгаа Оросын шигшээ баг Израиль, Нигер, Буркина Фасогийн араас 55 дугаар байрт бичигдэж эхэлсэн байна.

Ингэснээр Станислав

Черчесовын баг түүхэн дэх анти рекордоо шинэчлэн тогтоож байгаа аж. Өмнө нь Оросын шигшээ 53 дугаар байрт бичигдэж байсан юм. Оросын шигшээ багийн хувьд Европын аваргаар хэсгээсээ гарч чадаагүй. Тун муу амжилттай тоглож байгаа. Тэгвэл 2018 онд нутагтаа дэлхийн аварга шалгаруулах Оросууд нөхөрсөг тоглолтуудаа ч сайнгүй хийж байна. Хамгийн сүүлд гэхэд Катарын шигшээд 2:1-ээр хожигдсон. Гэх мэт муу тоглолтууд нь тэдний чансааг бууруулж, түүхэндээ байгаагүй анти рекордыг үзүүлээд байна.

## "Манчестер Юнайтед" Кейнд долоо хоногт 150 мянган фунтын цалин өгөхөд бэлэн

Английн алдарт "Манчестер Юнайтед" клуб "Тоттенхэм"-ийн довтлогч Харри Кейныг худалдаж авахаар сонирхож эхэлжээ. Squawka-гийн мэдээлж байгаагаар "Улаан чөтгөрүүд" эдүгээ 23 настай англи эрд долоо хоногийн 150 мянган фунтын цалин өгөхөд бэлэн байгаа ажээ. Тэрбээр одоогоор Лондоны багаас долоо хоногтоо 60 мянган фунтын цалин авдаг юм байна. Гэхдээ "Тоттенхэм" түүний долоо хоногт 100 мянган фунт авах хүсэлтийг хүлээж аваад байгаа ч одоохондоо цалин нэмэх талаархи хэлэлцээр түр зогсоод байгаа аж. Өмнө нь "Манчестер Юнайтед" клуб Харри Кейны төлөө 50 саяаг төлөхөд

бэлэн байгаа талаар мэдээлэл гарч байсан. Түүний "Тоттенхэм"-тэй байгуулсан гэрээ 2020 оны зун дуусах учиртай. Одоогоор Кейныг "Реал", "Байерн", "Челси" болон "Манчестер Сити" клубүүд сонирхож байгаа билээ. Харри Кейн одоогоор Английн премьер лигийн зургаан тоглолтод оролцож, гурван гоол оруулж, нэг гоолын дамжуулалт өгчихөөд байгаа юм.



### Дэлхийн чансаа

- 1 (1) Аргентин – 1634
- 2 (3) Бразил – 1544
- 3 (2) Герман – 1433
- 4 (6) Чили – 1404
- 5 (4) Бельги – 1368
- 6 (5) Колумб – 1345
- 7 (7) Франц – 1305
- 8 (8) Португал – 1229
- 9 (9) Уругвай – 1187
- 10 (10) Испани – 1166
- ...
- 50-52 (67) Брукина-Фасо – 616
- 50-52 (60) Нигер – 616
- 50-52 (52) Словен – 616
- 53 (45) Гана – 611
- 54 (79) Израиль – 595
- 55 (53) Орос – 592


## "Барселона" "Ракутен"-ээс дөрвөн жилд 55 сая евро авна

Испанийн алдарт "Барселона" клубын өмсгөл дээр 2017-18 оны улирлаас Японы "Ракутен" компанийн лого байршихаар болсон билээ. Интернет арилжаа эрхэлдэг дэлхийн хамгийн том компаниудын нэг "Ракутен" дөрвөн жилийн турш жилд 55 сая еврог "Барса"-д төлөх аж. Хэрвээ Аваргуудын лигт түрүүлбэл тав, Ла лигийн аварга болбол 1.5 сая еврогийн урамшуулал нэмж авах ажээ. Каталонь багийн өмсгөлийн спонсорор сүүлийн зургаан жилд The Qatar Foundation болон Qatar Airways компаниуд ажиллаж байсан. Харин шинэ хамтрагчийг

олоход клубын тоглогч Жерар Пике чухал үүрэг гүйцэтгэжээ. Пике болон түүний эхнэр Шакира нар "Ракутен"-ий захирал Хироши Микитанитай 2015 онд Сан Францискод анхны уулзалтыг хийж байсан аж. 1997 оноос үйл ажиллагаа явуулж буй, жилийн 700 сая йений орлоготой "Ракутен" нь Японы дээд лигийн "Виссель Кобе" багийг мөн ивээн тэтгэн ажилладаг юм. Хөлбөмбөгийн ертөнцдэх хамгийн үлэмж өмсгөлийн спонсорын гэрээг "Манчестер Юнайтед" клуб Chevrolet-той байгуулсан. 2012 онд Chevrolet жилийн 53 сая фунтын гэрээг "Улаан чөтгөр"-үүдтэй долоон жилээр байгуулсан юм.

## "Тоттенхэм" нэгдүгээр сард Старрижийг авах оролдлого хийнэ

Английн алдарт "Ливерпүүл" клубын довтлогч Даниэл Старриж өвлийн солилцоо наймааны цонхоор багаа сольж магадгүй байна. Өдгөө 27 настай Английн шигшээн довтлогчийг өнгөрсөн зун "Тоттенхэм" сонирхож байсан билээ. Лондоны баг түүнийг 40 саяар үнэлж байсан. Тэгвэл энэ өвлийн солилцоо наймааны цонхоор түүнийг авах оролдлого дахин хийх ажээ. Старриж одоогоор премьер лигийн найман тоглолтод оролцож, гурван гоолын дамжуулалт өгчихөөд байгаа билээ.



## АУДИТ ХИЙХ ТУХАЙ

2016 оны 11 сарын 18-ны өдөр Улаанбаатар хот

**Ажил үйлчилгээний нэр:** "Багануур" ХК-ийн хүрэн нүүрсний ордод байгаль орчны аудит хийх

- Тухайн байгууллагын товч танилцуулга, ажлын туршлага  
- Ажлын зардлын задаргаа, үнэлгээ

"Багануур" ХК нь Байгаль орчны аудит хийх ажил, үйлчилгээ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах гэж байгаа тул ажлыг гүйцэтгэх хүсэлтэй хуулийн этгээдийг үнийн саналаа албан бичгээр ирүүлэхийг урьж байна.

*Гадаадын этгээд материал ирүүлэхгүй.*

Саналаа ирүүлж буй хуулийн этгээд нь дараах материалыг бүрдүүлж, баримт бичгийн баталгаажуулсан хуулбарыг хавсарган ирүүлнэ.

Сонирхсон хуулийн этгээд ажил үйлчилгээтэй холбогдолтой мэдээллийг ажлын өдөр ажлын цагаар /08:00 цагаас 17:00 цаг/ "Багануур" ХК-ийн Үйлдвэр технологийн хэлтэс Экологичинженерээс авч болно. Утас: 99034493, 88034493

**Үүнд:**  
- Байгаль орчны аудит хийх эрхийн гэрчилгээ

*Сонгон шалгаруулалтын материалыг 2016 оны 11-р сарын 25-ны өдрийн 17:00 цаг хүртэл Багануур дүүрэг "Багануур" ХК-ийн захиргааны байр 309 тоот Үйлдвэр технологийн хэлтэст ирүүлнэ.*

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2016 оны 11-р сарын 18

**Тендер шалгаруулалтын нэр:** "Багануур" ХК-ийн 2016 онд хэрэглэх сэлбэг материал нийлүүлэгчийг сонгох

"Багануур" ХК эрх бүхий тендер оролцогчдоос дараах тоног төхөөрөмж, бараа үйлчилгээнд оролцох тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

**Үүнд:**

№	Тендерийн нэрс	Дугаар	Хүлээн авах эцсийн хугацаа	Тендер нээх хугацаа	Материалын үнэ
1	Зам усалгааны автомашин	СПУ № БНХК-2016.03-02.1	2016 оны 12 сарын 19-ний 09 цаг	Мөн өдрийн 09 цаг 30 минут	50000 төгрөг
2	10 тонны даацтай ачааны автомашин	СПУ № БНХК-2016.03-04.1	2016 оны 12 сарын 19-ний 10 цаг	Мөн өдрийн 10 цаг 30 минут	50000 төгрөг
3	Хүн тээврийн автобус	СПУ № БНХК-2016.03-09	2016 оны 12 сарын 19-ний 11 цаг	Мөн өдрийн 11 цаг 30 минут	50000 төгрөг
4	Түлш зөөвөрлөгч автомашин	СПУ № БНХК-2016.03-10	2016 оны 12 сарын 19-ний 13 цаг	Мөн өдрийн 13 цаг 30 минут	50000 төгрөг

Тендерийн баримт бичгийг бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь Худалдаа Хөгжлийн банкны 499031495 тоот дансанд дээрх жагсаалтад заагдсан үнээр эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютыг тушаасан баримтаараа худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

**Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 3 жил

Тендерийн баталгаа нь санал болгож буй нийт үнийн дүнгийн 2%-наас доошгүй байх

Тендерийг нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан "Багануур" ХК-ийн захиргааны байранд нээнэ.

*Сонирхсон тендер оролцогч тендерийн баримт бичгийг ажлын өдөр ажлын цагаар хаяг №1-ээс худалдан авах, тендертэй холбогдолтой мэдээллийг хаяг №2-оос авч болно.*

**Хаяг №1: Улаанбаатар хот. Баянзүрх дүүрэг. "Багануур" ХК-ийн төлөөлөгчийн байр. Төлөөлөгч Ц.Баяраа**  
Утас : 451740, 99023137  
Факс : 457715

**Хаяг №2: Техникийн хэлтсийн дарга Д.Бямбажав**  
Утас: 7021-0351

**Техникийн хэлтсийн инженер Н.Алтантулга** Факс: 7021-0351

БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИ

БАГАНУУР ХУВЬЦААТ КОМПАНИ

# СПОРТ

## ЯРИЛЦАХ ТАНХИМ

Төгсгөл.  
Түрүүч нь V нүүрт

Тэр хүсэлтийн дагуу манай багаас таван тоглогч үлдэж ажиллахаар болж байсан юм. Ингээд л 2012 оноос хойш цагдаагийн байгууллагад орж ажиллаад таван жил болж байна даа.

**-Одоо тэгээд цагдаагийн байгууллага даа харьяалагдадаг сагсан бөмбөгөө тоглодог уу. Эсвэл цагдаагийн ажлаа хийхийн хажуугаар сагсан бөмбөгөө амжуулах уу?**

-2012 онд 45 хоногийн курст яваад, цагдаа болсон. Би одоо эргүүлийн цагдаа хийдэг. Таван жилийн турш эргүүлийн цагдаагийн ажлаа хийгээд л явж байна даа. Байнга эргүүлд гарна. Хэрвээ тэмцээнд оролцохоор болбол ажлаас чөлөө олгоно. Гэхдээ байнга чөлөө өгнө гэж



Үндэсний аваргын бөгж гардуулах ёслолын үеэр

лигийн тэмцээнийг гаргаж байна. Ерөөсөө Монголын сагсан бөмбөгийн спорт сайн хөгжиж байгаа. Шүүлтгийн хувьд ч давуу талтай болсон. Бичлэг ухрааж үздэг болчихлоо. Хуучин тийм юм байдаггүй л байсан шүү дээ. Спортын ордуудад болж байгаа тоглолтыг үзнэ. Хэдийгээр зав муутай ч гэсэн бүх ажлаа зохицуулаад л Хандгайт руу ч юм уу явдаг. Эмэгтэй лигийн нээлт Хандгайтын сагсан бөмбөгийн ордонд болж байсан. Хэдий хол ч гэсэн дургтай зүйлийнхээ төлөө явна шүү.

**-Эрэгтэй тамирчдын ур чадвар харьцангуй дээшлж байна. Гадаадаас тамирчид авчирч ирж байгаа нь ч нэлээд нөлөөлж байгаа болов уу. Харин эмэгтэй сагсан бөмбөгчдийн чадвар ямар хэмжээнд байгаа гэж боддог вэ?**

-Тухайн дасгалжуулагчаасаа

# Э.Одонцэцэг: Цагдаагийн ажил Зав багатай 1 бэлтгэлээ тасралтгүй хийж, ур чадвараа бууруулахгүй хийгээдэ

юу байх билээ. Гол гол тэмцээнд оролцох болохоор л чөлөө гуйна. Өнгөрсөн жил хэлтсийн даргаасаа чөлөө авч, тэмцээндэ орж байсан. Лигийн тэмцээнийн тоглолтууд 1, 3, 5 дахь болно. Би 2, 4 дэх өдөр ажлаа хийчихээд, тоглолтоотой өдрөө чөлөө аваад л явна. Ажлынхаа хажуугаар бэлтгэл сургуулилтаа амжуулаад л явдаг байсан. Одоо ч гэсэн ажлынхаа хажуугаар бэлтгэлээ хийдэг.

**-Цагдаа тамирчин байхын жаргал, зовлонгоосоо хуваалцаач?**

-Хэцүү үе зөндөө л гардаг. Наад зах нь л байнгын чөлөө гуйх чинь хэцүү шүү дээ. Ажлаа нэгдүгээрт тавих ёстой болдог. Ерөөсөө цагдаагийн байгууллагад орсон л бол ажлаа нэгдүгээрт тавих хэрэгтэй болно. Тэгээд дараа нь ар гэр, үр хүүхдээ анхаарна. Цагдаагийн байгууллагад орж ажилласнаас спортыг нэгдүгээрт тавихаа больсон доо.

**-Улаанбаатар хотын цагдаагийн газрын түүхт 90 жилийн ой энэ өдрүүдэд тохиожбайгаа. Нийслэлийнхээ амгалан тайван байдлын төлөө ажиллаж байгаа цагдаа хүний хувьд ажлаа бахархаад ярьвал?**

-Хуучин Нийслэлийн хөдөлгөөнт эргүүлийн газар байсан. Хөдөлгөөнт эргүүлийн газар таван жил болоод татан буугдахад албан хаагчид нь дүүргүүдэд хуваарилагдаж очсон. Ингэснээр дүүргүүдийн

албан хаагчдын тоо өссөн. Хан-Уул дүүргийнх ч ялгаагүй. Тухайн үед бол Хан-Уул дүүргийн цагдаагийн газар гэж байсан юм. Улмаар албан хаагчид нь нэмэгдээд ирэхээр 2012 оны арванхоёрдугаар сард Хан-Уул дүүргийн цагдаагийн 1, 2 дугаар хэлтэс болж хуваагдсан. Манай цагдаагийн хоёрдугаар хэлтэс 2012 оны арванхоёрдугаар сарын 9-нд байгуулагдаж байлаа. Миний хувьд Нийтийн хэв журмын тасагт харьяалагддаг. Одоогоор Мөрдөн байцаах тасаг, Эрүүгийн тасаг гэх мэт таван тасагтай үйл ажиллагаагаа явуулдаг. Би 2013 онд Баянзүрх дүүргээс энэ хэлтэст шилжиж ирж байсан. Түүнээс хойш энэ хэлтэстэй дөрвөн жил ажиллаж байна даа.

**-Эмэгтэй хүн эргүүлийн цагдаа хийнэ гэдэг тийм ч амар биш. Ер нь яагаад цагдаагийн байгууллагыг сонгож ажиллахаар болсон юм бэ?**

-Би цагдаа болох хүсэлтэй хүүхэд байсан. Дунд сургуулиа Дарханд төгссөн. Тэр үед Цагдаагийн академийн хуваарь Дарханд жил алгасч очдог байсан юм. Гэтэл намайг төгсдөг жил Цагдаагийн академийн хуваарь ирээгүй. Тэгэхээр нь Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуульд орсон. Тэнд сурч байхдаа сагсан бөмбөгөө тоглоод л явдаг байлаа. Гэтэл 2012 онд Бүх ард түмний спартакиад болж, надад цагдаа болох боломж гарч ирсэн.

...Ямар ч тэмцээнд орсон медалиас мултардаггүй. Цагдаагийн байгууллагуудын дунд "Хүч" спорт хорооноос зохион байгуулагд "Хүчийн аварга" гэдэг тэмцээн болдог...

Тэгэхээр нь тэр дор нь барьж аваад л, цагдаа болох хүслээ гүйцэлдүүлсэн дээ. Одоо бол би эчнээгээр сураад, гурван жилийн дараа офицер болох боломжтой. Миний хамгийн ойрын төлөвлөгөө офицер цол авах л байна даа.

**-Цэрэг, цагдаагийн байгууллагуудын хооронд янз бүрийн тэмцээн болж байгаа харагддаг. Тэр тэмцээнүүдэд оролцож, авьяас чадвараа мэдрүүлнэ биз?**

-Ямар ч тэмцээнд орсон медалиас мултардаггүй. Цагдаагийн байгууллагуудын дунд "Хүч" спорт хорооноос зохион байгуулагд "Хүчийн аварга" гэдэг тэмцээн болдог.

Дүүргүүд, газар хэлтсүүд тусдаа баг бүрдүүлж оролцоно. Хөдөө, орон нутгаас багууд ирж оролцдог, том тэмцээн болдог. Тэр тэмцээнд 2013, 2014, 2015, 2016 онд Хан-Уул дүүргийн цагдаагийн II хэлтсийнхээ багтай оролцоод, түрүүлсэн. Мөн шилдэг тоглогчийн шагналыг ч авсан. Мөн нийслэлийн цагдаагийн шигшээ багтаа багтдаг. Тэр шигшээ багтайгаа хамт бас Мэргэжлийн хяналтын нэрэмжит Улаанбаатар хот байгуулагдсаны ойн сагсан бөмбөгийн тэмцээнд дөрвөн жил дараалж аваргалсан. Ерөнхийдөө манай цагдаагийн эмэгтэй баг амжилттай оролцдог. Би түрүүнд "Хөвсгөл нэг үе" гэдэг багийн таван тамирчин цагдаагийн байгууллагад үлдэж ажиллахаар болсон гэж хэлсэн дээ. Нэг охин маань Төрийн тусгайд ажилладаг. Харин нөгөө дөрөв нь одоо цагдаадаа ажилладаг. Тэр хэдтэйгээ нийлээд, шигшээ баг болоод л орно. Бусад жижиг тэмцээнд бол дөрвүүлээ бие биенийхээ эсрэг л тоглодог юм. Өөр, өөр хэлтэст ажилладаг болохоор.

**-Өнгөрсөн жилээс авахуулаад Монголын Үндэсний Сагсан бөмбөгийн холбооноос эмэгтэйчүүдийн супер лигийн тэмцээнийг зохион байгуулж эхэлсэн. Энэ тэмцээнд өөрийн тань тоглодог Үндэсний биенийн тамирын дээд сургуулийн "Best Cashmer" баг түрүүлсэн байх аа?**

-Хуучин эмэгтэйчүүдийн лиг

"Спрайт лиг" гэдэг нэртэйгээр зохион байгуулагддаг байсан юм. Тэр тэмцээнд манай "Хөвсгөл нэг үе" баг гурван жил дараалж түрүүлж байлаа. Би тэр багаасаа гараад, "Танан импекс" гэдэг багт тоглож байлаа. Дундуур нь бас үр хүүхэдтэй болоод, сагсан бөмбөгөөсөө хэсэг зуур завсарлага авсан. Харин өнгөрсөн жил буюу 2015-2016 оны улиралд МҮСБХ эмэгтэй дээд лигт зохиохоор болсон. Улмаар бүх эмэгтэй сагсан бөмбөгчдөө драфтласан юм. Улмаар зургаан баг болж хуваагдсан. Манай Үндэсний биенийн тамирын дээд сургуулийн "Best Cashmer" баг ерөнхийдөө сугалаагаар бүрдсэн гэж ойлгож болно. Тэгэхдээ тун сайн тамирчид энэ багт багтсан болохоор улирлын тоглолтод ердөө л ганц хожигдсон. Улмаар лигийн аварга болж, алтан медаль, аваргын бөгжөөр шагнуулсан.

**-Монголын эмэгтэй шигшээ баг Олон улсын тэмцээн уралдаанд оролцдог болж эхлээд байна. Шигшээ багт багтах боломж байгаа юу?**

-Шигшээ багт арай залуу тамирчдыг дуудаж байгаа. Мөн илүү туршлагатай, олон жил тууштай тоглосон хүмүүс багтдаг юм.

**-Монголын сагсан бөмбөгийн спорт харьцангуй хөгжиж эхэллээ. Эрэгтэйчүүдийн лигийн тэмцээнийг бол байнга үзнэ биз. Спортын ордон руу явах зав олдож байна уу?**

-Ер нь байнга үздэг. Одоо бүхий л телевизээр гаргадаг болсон. Гадаад, дотоодын

л шалтгаална гэж боддог. Тэр багтай ажиллаж, нэг баг болгож чадахгүй бол хэчнээн сайн тамирчинтай байсан амжилтад хүрч чадахгүй. Манай багийн өнгөрсөн жил Болормаа гээд Монгол III сургуулийн захирал байсан хүн дасгалжуулсан. Эмэгтэй хүн гэдэг утгаараа бүх тамирчиддаа хүрч ажиллаж байсан. Аваргын төлөөх тоглолтын өмнө сэтгэлзүйч авчиргаад, бидэнтэй бүгдтэй нь уулзуулж байлаа. Тэгэхээр чинь бүгд аварга болох зорилготой, зоригтой болж байсан. Энэ мэтээр дасгалжуулж л чадвал эмэгтэй тамирчдын ур чадвар тийм ч муудахгүй гэж би боддог.

**-Өмнө нь сагсан бөмбөгт ихэнх цаг заваа зарцуулаад явдаг байсан байх. Харин одоо бол ажлаа нэн тэргүүнд тавихаас өөр аргагүй. Тийм болохоор бэлтгэл сургуулиг хийх цаг олдохгүй, ур чадвараа буурах асуудал гарч байна уу?**

-Миний хувьд бэлтгэлээ аль болох тасалдуулахгүй байхыг хичээдэг. Даргаасаа чөлөө авна, бэлтгэлээ хийнэ. Ур чадвараа бууруулахгүй байхыг хичээж байгаа. Долоо хоногтоо мягмар, пүрэв, бямба, ням гээд дөрөв хоног хийдэг. Лигт оролцсон багийнхандаа хамтраад л бэлтгэлээ хийдэг юм. Энэ жилийн хувьд лиг хэзээ эхлэх нь тодорхой биш байгаа. Тийм болохоор албан ёсны бэлтгэл эхлээгүй л байна. Гэхдээ л би хувийн бэлтгэлээ байнга хийгээд, ур чадвараа сайжруулах тал дээр анхаараад л явж байна даа.

MMINFO

## ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ

**MMINFO АПП**

Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

TATA PLAY STORE

TATA APP STORE

## СПОРТ

ДУУЛГАХ СОНИН

## Чиндаогийн ГРАН ПРИ өнөөдөр эхэлнэ

Н.БОЛД

БНХАУ-ын Чиндао хотноо өнөөдөр Олон улсын жудо бөхийн холбооны 2016 оны хамгийн сүүлчийн Гран при ангиллын тэмцээн эхлэх юм. Энэ удаагийн Чиндаогийн Гран при дэлхийн 15 орны эрэгтэй 85, эмэгтэй 70, нийт 155 жүдоч өрсөлдөх юм байна. Хятад улс зохион байгуулагч орон гэдэг утгараа давуу эрх эдэлж, нэг жинд дөрвөн жүдоч оролцуулж байгаа юм.

Тиймдээ ч эрэгтэй 26, эмэгтэй 30 Чиндаогийн татамид гарахаар болжээ. Мөн Азид болж байгаа гэдэг утгаараа Олимпын наадмаас хойш Гран при тэмцээнд тамирчдаа оролцуулаагүй Япон, Солонгосын багцөөн тооны жүдочоо илгээсэн байна. Японоос эрэгтэй, эмэгтэй тус бүр дөрвөн тамирчин очиж байгаа бол Солонгос эрэгтэй найм, эмэгтэй дөрвөн тамирчин энэхүү тэмцээнд оролцохоор болсон байна. Мөн Оросын баг эрэгтэй 11, эмэгтэй 12 тамирчнаа илгээсэн нь хамгийн ихэд тооцогдож байгаа юм. Тэгвэл Монголын шигшээ багаас эрэгтэй 11, эмэгтэй хоёр, нийт 13 тамирчин Чиндаог зорьсон билээ. Олимпын наадмаас хойш хэд хэдэн тэмцээн болоход манайх 1-2 тамирчин л оролцуулсан. Тэр ч битгий хэл Абу Дабигийн "Их дуулга" ангиллын тэмцээнд манайхаас 48 кг-ын жинд Гавьяат тамирчин М.Уранцэцэг ганцаараа оролцсон.

Тэгвэл энэ удаад 13 тамирчин Чиндаогийн Гран при оролцохоор очсон нь Олимпын наадмаас хойш хамгийн олон жүдоч хилийн дээ алхсан явдал байлаа. Уг нь Монголын жудо бөхийн холбооноос энэ тэмцээнд оролцох тамирчдыг өөрсдийнхөө зардал мөнгөөр явахыг сануулсан мэдээлэл гарч байсан. Тэгж үзвэл манай тамирчид өөрсдөө зардлаа гаргаж, Олон улсын тэмцээнд оролцохоор явж байгаа бололтой. Туршлагатай тамирчдаас 60 кг-ын жинд Дэлхийн аваргын мөнгөн медальт Д.Амартүвшин, дэлхийн аваргын хүрэл медальт Ц.Мөнхзаяа болон ОУХМ А.Батсуурь, Д.Алтансүх нар оролцож байгаа билээ.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

## Чиндаогийн Гран при оролцох тамирчид

**60 кг:** Дашдавагийн Амартүвшин /Дэлхийн аваргын мөнгөн медальт/  
**66 кг:** Довдонгийн Алтансүх /ОУХМ, Азийн аварга/  
**66 кг:** Адъяагийн Батсуурь /ОУХМ, 2016 оны улсын аварга/  
**73 кг:** Ганболдын Чойжилсүрэн /Жудо академи/  
**73 кг:** Болдбаатарын Баяндүүрэн /Фүкүй дээд сургууль/  
**81 кг:** Нямсүрэнгийн Дагвасүрэн /ОУХМ, Азийн аварга, багийн ДАШТ-ий хүрэл медальт/  
**90 кг:** Гантулгын Алтанбагана /ОУХМ, "Алдар" спорт хорооны

тамирчин/

**90 кг:** Одхүүгийн Цэцэнцэнгэл /"Тэмүүлэл" дэвжээ/  
**-100 кг:** Хутагын Цогтгэрэл /ОУХМ, "Алдар" спорт хороо/  
**-100 кг:** Батбаатарын Билгүүн  
**+100 кг:** Өлзийбаярын Дүүрэнбаяр /ОУХМ, Залуучуудын дэлхийн аварга/  
 Эмэгтэй  
**57 кг:** Лхагватоогогийн Энхрийлэн /ОУХМ, ОБЕГ-ын "Аврагч" спорт хороо/  
**63 кг:** Цэдэвсүрэнгийн Мөнхзаяа /Монгол Улсын гавьяат тамирчин, ДАШТ-ий хүрэл медальт/

## МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

## Жудо бөхийн ахмадын дэлхийн аваргад есөн тамирчин оролцоно

АНУ-ын Флорида мужийн Майами хотноо Форт Лаудердэйл эрэг дээр жудо бөхийн ахмадын ДАШТ өнөө шөнө эхэлнэ. Тус тэмцээнд 55 улсын 841 эрэгтэй, 125 эмэгтэй, нийт 966 тамирчин оролцохоор мэдүүлгээ өгчээ. Үүнээс хамгийн олон тамирчнаа буюу 151 жүдоч АНУ-аас оролцох бол Франц 140, Бразил 133 тамирчнаа оролцуулах юм байна. Тэмцээнд манай улсаас нийт есөн

тамирчин оролцохоор мэдүүлгээ өгсөн. М1 ангиллын эрэгтэйчүүдийн -100кг-ын жинд ОУХМ Б.Ариун-Эрдэнэ хүч үзэх бол эмэгтэй F1 ангилалд ОУХМ Т.Энхцэцэг 63 кг-д өрсөлдөхөөр бэлтгэл сургуулилтаа базаагаад байна. Мөн M2 ангиллын 73 кг-д Д.Бат-Амгалан, 81 кг-д С.Мөнхонхуяг нар өрсөлдөх бол F4 ангилалд Р.Дэчинмаа, M7 ангилалд Н.Батсуурь нар эх орноо төлөөлөн оролцохоор болжээ.

## Г.Отгонцэцэг Казахстаны аварга боллоо

Казахстан улсын жудо бөхийн аварга шалгаруулах тэмцээн өчигдөр эхэлсэн билээ. Тэгвэл энэ удаагийн Казахстаны аварга шалгаруулах тэмцээний 48 кг-ын жинд тус улсын нэрийн өмнөөс барилдах болсон Монголын жүдоч Г.Отгонцэцэг түрүүлээ. Ингэснээр хоёр дахь жилдээ дараалан өөрийн жиндээ түрүүлж, Казахстаны хошой аварга боллоо. Тэрбээр энэ жил Риогийн Олимпын наадмаас хүрэл медаль хүртсэн. Мөн Олон улсын чанартай 10 тэмцээнд оролцохдоо

таван алт, хоёр мөнгө, гурван хүрэл медаль авч, 2016 оны шилдэг эмэгтэй жүдочоор шалгарсан билээ. Казахстаны шигшээ баг энэ удаад улсын аварга нь давхацсан учраас Чиндаогийн Гран при тэмцээнийг өнжиж байгаа аж. Харин Г.Отгонцэцэг ирэх сарын 2-нд эхлэх Токиогийн "Их дуулга" ангиллын тэмцээнд оролцох билээ.



## Монголын сагсчид дэлхийн аваргад оролцоно

БНХАУ-ын Шиамен хотноо маргааш оюутны дэлхийн аварга шалгаруулах 3x3 сагсан бөмбөгийн тэмцээн болно. Тэмцээнд таван тивийн шилдэг 32 эрэгтэй, эмэгтэй багууд өрсөлдөх юм. Монголын тамирчид энэ тэмцээнд Ази тивийг төлөөлөн оролцох эрхээ БНХАУ-ын Мүгдэн хотноо 2015 онд болсон ААШТ-д амжилттай оролцон мөнгөн медаль хүртсэн амжилтаараа авсан юм. Энэ тэмцээнд оролцох Монголын багийн бүрэлдэхүүнд Ази тивийн 2015 оны аваргын 3x3 тэмцээний мөнгөн медальт А.Гансүх, Э.Дөлгөөн, Б.Батзолбоо, Г.Чинбат нар багтсан юм. Багийн дасгалжуулагчаар С.Тулга, ахлагчаар Мон-Алтнүс БТДС-ийн захирал М.Өсөхбаяр нар хамт явж байгаа юм. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн маргааш эхлээд 24-ний өдөр өндөрлөнө.

## ЭЛСЭЛТИЙН ЗАР

"Зохиомж" дээд сургууль 2016-2017 оны хичээлийн жилд дараах мэргэжлүүдээр өдөр, орой, эчнээ, хөрвөх ангид 4 жил, 2.5 жил, 1.5 жилийн бакалаврын ангид нэмэлт элсэлт авна.

1. Телевизийн сэтгүүлч, зураглаач
2. Кино, драмын жүжигчин
3. Кино, телевизийн найруулагч
4. Бага ангийн багш
5. Сургуулийн өмнөх боловсролын багш
6. Эрх зүй
7. Санхүү, банк
8. Нягтлан бодох бүртгэл, татвар
9. Гааль, гадаад худалдаа

## Жич:

- IX/1 –нээс хойш судалсан хичээлүүдийг нэмэлт цагаар нөхүүлнэ
- Өнгөрсөн хугацаанд өөр сургуульд судалсан хичээлүүдийн дүнг тооцож үргэлжлүүлэн суралцах боломж олгоно.

Сэтгүүл зүй, Урлаг судлал, Бизнесийн удирдлага ангиудад магистрын элсэлт авна.

Холбоо барих утас: 70155585, 91111187, 99608440, 80818021

ТӨСӨӨЛЛӨӨС ИЛҮҮГ ТЭНГИСЭЭС...

## ХЯМДРАЛ, УРАМШУУЛАЛ

Даваа Мягмар Лхагва Пүрэв Баасан Бямба Ням

ЭХНИЙ ҮЗВЭР БҮР ХЯДРАЛТАЙ: Төм хүн - 5000Т, Хүүхэд - 4000Т

Хосуудын өдөр	Оюутаны өдөр	Ахмадын өдөр
Хосоороо ирсэн хүн бүрт тасалбар <b>5000Т</b>	Өдрийн дурш оюутануудад тасалбар <b>5000Т</b>	10:00-17:00 Цагийн хооронд тасалбар <b>4000Т</b>

### ТӨРСӨН ӨДРИЙН УРАМШУУЛАЛ

Тасалбараа авнаг → Ундаа Попкорн → Үнэмлэрийн